УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

# Багш ажлын байран дээр хөгжихөд багш нарын хамтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх арга зам

Биеийн тамирын багш Л.Энхмөнх
ХАБ,ЭА-н багш : Б.Энхцэцэг

Говьсүмбэр аймаг
2020 он

## АГУУЛГА

**ОРШИЛ**

1. Удиртгал
2. Илтгэлийн хураангуй
3. Түлхүүр үг
4. Судалгааны үндэслэл
5. Судалгааны зорилго
6. Судалгааны зорилт
7. Судалгааны шинэлэг тал
8. Судалгааны арга зүй

**НЭГ:** ОНОЛЫН ХЭСЭГ

**ХОЁР :** СУДАЛГААНЫ ХЭСЭГ

9. Дүгнэлт
10. Ном зүй

## ОРШИЛ

Өөртөө байхгүй юмыг өөр бусдад өгч чадахгүйтэй адил хөгжөөгүй боловсролгүй, хүмүүжилгүй хүн бусдыг хөгжүүлж, боловсруулж, хүмүүжүүлнэ гэж байхгүй гэж Германы эрдэмтэн Дистервег хэлсэн байдаг. Иймд багш хүн өөрийгөө ямар ч чиглэлээр хөгжүүлж, бусдаас цаг ямагт суралцаж байх шаардлагатай нь харагдаж байгаа ба үүний дараа бид бие биендээ суралцагчдадаа зааж зөвлөж, суралцагчидаасаа суралцах үйл явц урган гарах юм.

***Жишээ нь:***

***Мэргэжилтэй холбоотой аль нэг албан байгууллагын нэг ажилтан, ажил олгогч, мэргэжил нэгтэй багш нар, болон хамт ажилдаг хүмүүсээс тогтмол суралцах, хөтөлбөр боловсруулах, заах арга гэх мэтчилэн***

Өөрөөр хэлбэл багш бидний сургах, хүмүүжүүлэх, төлөвшүүлэх хувь хүн маань сурагч гэдэг асар том объект юм. Ийм зарчмын шинэ зорилтыг хэрэгжүүлэхэд багш бидний хамтын үйл ажиллагааг дэвшүүлэх нь зайлшгүй болоод байна .

Орчин үед шинжлэх ухаан техник технологийн эрчимтэй хөгжлийг дагаад хүүхдийн сэтгэхүй, оюун ухаан юмсыг хүлээн авах, тэдгээрт хандах хандлага эрс хурдацтай хөгжиж байна. Тиймээс энэ хөгжлийг дагаад багш заах арга зүйгээ өөрчлөлт гаргах ёстой учраас аливаа техник, сургалтын хэрэгсэл хэрэглэгдэхүүн, орон нутгын нөөц боломж бололцоог сургалтандаа ухаалгаар ашиглах ур чадвараа хөгжүүлэх технологи арга зүйн шинэчлэлийг байнга эрэлхийснээр тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой. Өөрөөр хэлбэл орон нутгийн байршил боломжоос өндөр үр дүн, шийдлийг олж харах бүтээлч сэтгэлгээ чухал.

***Жишээ нь:***

***Манай орон нутагт боловсрол, уул уурхай, барилга хот тохижуулалтын төрийн болон хувийн хэвшлийн хичнээн аж ахуйн нэгж байдаг билээ. Тэдгээрт манайд бэлтгэж байгаа мэргэжилүүдээс хичнээн нь хэрэгтэй вэ? Өөрөөр хэлбэл албан байгууллаг аж ахуй нэгж бүрт нярав, нягтлан, хаб-н ажилтан, мөн орчны цэцэржүүлэлт, зуны цагийн жижиг засал чимэглэлийн ажил гэх мэтийн боломж бололцоог олж харж нэг байгууллагын нэг ажилтанд 1 хүүхдийг дагалдуулах, дагалдуулж буй суралцагчдийн тулгарч буй асуудлыг шийдвэрлэх замаар багш давхар хөгжиж болно.***

Багшийн ажлын байрандаа хөгжиж түүний сэтгэл ханамжийн тухай асуудал нь нэг их анзаарагдаж, ажиглагдаад байдаггүй ч өнөөгийн нийгэмд бүр цаашилбал мэргэжлийн боловсролын салбарын нэг чухал шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг болжээ.

***Жишээ:***

***Өөрөөр хэлбэл хөгжиж чаддаг багшийн шавь улам сайн хөгждөг. Багш цаг ямагт сурагчдаа үлгэрлэж байдаг гэдгийг харуулж байна. Аливаа боломж бололцоог олж харж түүнийг шийдвэрлэх арга замыг судалж асуудал дэвшүүлж шийдвэрлэж чаддаг байх***

Тиймээс ч энэ сэдвийг сонгож сэдвийн бусад асуудлыг хөндөж түүний учир шалтгааныг олох гэж энэхүү илтгэлийг бичсэн юм.

Энэхүү илтгэл нь оюуныг эрхэмлэгч багш та бүхэндээ бага ч болов дэм болно гэдэгт итгэж байна. Та бүгдийн саруул ухаантай элит боловсролтой, ирээдүйд лидер болох зам бүхэн чинь гэгээн байх болтугай.

**Хураангуй**

Эдүгээ цаг үед хамтын ажиллагааны шинэ хэв маяг хэлбэрүүд бий болж улмаар зөв зохион байгуулагдсан нэгдсэн хамт олны зорилго, чиглэл үйл ажиллагааны эерэг давуу тал нь илт нэмэгдэж, байгууллага хамт олон, нэгж бүр бие биеэ нөхөн гүйцээж давуу талаа ашиглан багийн зохион байгуулалтыг эрхэмлэх болов. Гэсэн ч бидний дунд сургуулиудын орчинд хамтарч ажиллах аргаа олоогүй, энэ талаар үр ашигтай ажил санаачлага өнөө хэр дутмаг байсаар байна. Тухайлбал орон нутаг дахь боловсролын байгууллагууд жилд ганц удаа спортын тэмцээнүүд, аюулгүй ажиллагааны давтан сургалт бүс нутгийн хэмжээнд боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааны цар хүрээ жилдээ ганц удаа нээлттэй хичээл, илтгэл хэлэлцүүлэг, спортын тэмцээнүүдээр хязгаарлагддаг нь хамтын ажиллагаа хангалттай бүрдээгүйг харуулж байна.

Өнөөдөр аль ч газар хэвлэл мэдээллээр дамжуулан багш мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж өргөн байгаа ч ихэнх багш нарын хамтын ажиллагаа, оролцоо дутмаг байна. Тиймээс бид энэ байдлаас гарах тодорхой асуудал загварын санал дэвшүүлж байна.

**Түлхүүр үг**

Багш, багшийн хөгжил, хамтын ажиллагаа, хамтран хөгжих, заах аргын нэгдэл, багш нарын бүтээлч хамтын ажиллагаа, боловсролын шинэчлэл, сургалт, семинар, хөрвөх чадвар.

**Сэдвийг сонгосон үндэслэл, өнөөгийн шаардлага**

Багш хүнд хэдийгээр онолын мэдлэг чухал боловч сурган хүмүүжүүлэх ухааны нарийн ээдрээтэй олон талт асуудалтай өдөр бүр л тааралддаг. Хүн болгон адилгүй хүлэг болгон жороогүй гэдэг шиг багш бүрийн өөр өөрийнхөө хэмжээнд эзэмшсэн мэдлэг дадал, чадвар, туршлага, заах арга зүй удирдан зохион байгуулах авьяас бүгд өөр өөр байдаг.

Харин энэ бүхнийг бусадтайгаа хуваалцаж бусдаасаа суралцсанаар бид бүхний ажлын амжилт сайжирч улмаар нэг хамт олны бүлээн дулаан уур амьсгал бүрдэх нөхцөл бий болох сайн талтай. Хөдөө орон нутагт мэргэжлийн багш нар ганц нэгхэн байдаг болохоор хамтарч хөгжихөд ихээхэн бэрхшээл учирдаг зэрэг маш олон асуудлаас улбаалан багш анхан шатны нэгж болох ажлын байрандаа хөгжих асуудал зайлшгүй урган гарч байна. Тиймээс энэ сонирхолтой асуудлыг сонгон авч, шийдвэрлэвэл зохих санал дэвшүүлсэн болно.

*Жишээ нь:*

***Манай орон нутгын хэмжээнд 5 Ерөнхий боловсролын сургуулиуд байдаг. Тэдгээрт нийгэм, газар зүй, биологи, хими, монгол хэл, физик, математик, англи хэл, биеийн тамир гээд агуулгын хувь нээх хол зөрөөгүй ерөнхий эрдмийн хичээлүүд ордог эдгээр багш нар хамтран бие биеэсээ суралцах, багш солилцоо хийх, хичээлийн төрлөөсөө хамааран өөрийн чиглэлийн ахмад гавьяат багш нарыг урьж авчран уулзалт ярилцлага семинар зохион байгуулах, шийдвэрлэх асуудлуудаа хэлэлцэх ярилцах зэрэг ажилбаруудыг зохион байгуулж болох юм гэсэн санаа. Эсвэл ерөнхий боловсролын заах арга зүйн нэгдлээр нь хамаараад манай багш нар тэр нэгдэлд нь орох хэрэгтэй. Эдгээр асуудлаар аймгийн БСГ-тай хамтран зохион байгуулах.***

**Сэдвийн судлагдсан байдал**

Багшийн мэргэжил сонголт, ажлын байрандаа хөгжих явц түүндээ хандах сэтгэл хангалуун байдал ханамжийн тухай мөн түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн тухай бидний сонгосон энэхүү сэдвийн хүрээнд нийтлэг ерөнхий тогтолцоо илрүүлсэн, энэ төвшинд хийсэн онолын болон хэрэглээний суурь судалгаа өнөө хэр хийгдээгүй байна. Гэхдээ багш хөгжлийн асуудлын хүрээнд уг сэдэв болон түүнтэй холбогдох хамаарах олон асуудлыг авч үзсэн судалгааны ажил олон буйг бас тэмдэглэж байна.

**Судалгааны зорилго**

Багш хөгжлийн хүчин зүйлийг тодорхойлсон, оновчтой зөв зохион байгуулалт бүхий эерэг үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх арга зам боломжийг судална.

**Судалгааны зорилт**

1. Хамтын ажиллагаанд суурилсан хөгжлийн онцлог ба орчин үеийн багшид тавигдах шаардлага
2. Багшийн хөгжилд хамтын үйл ажиллагаа нөлөөлөх нь
3. Багш ажлын байранд хөгжихөд хичээлийн судалгаа нөлөөлөх нь
4. Өрнө дорны орнуудын монголд хэрэгжүүлж болохуйц туршлагууд
5. Багш нарын хамтын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга замаар багш нарыг хөгжүүлэх боломжууд

**Судалгааны арга**

Уг илтгэлийг бичихдээ санал асуулга, ажиглалт, анкетын арга, асуудал дэвшүүлэх шийдвэрлэх . харьцуулан нэгтгэх, дүгнэх аргуудыг хэрэглэсэн.

**Судалгааны шинэлэг тал**

Эдүгээ хүний хөгжлийн асуудлыг нийгмийн хүчин зүйлтэй холбон үзэж байгаа энэ цаг үед багшийн хөгжил төлөвшлийн асуудлыг хамтатгах, хамт олны тодорхой зорилго бүхий нэгдсэн чиглэл үйл ажиллагааны хүрээнд тодорхой орчин нөхцөлд хэрхэн өрнөж буй байдлыг тодорхойлон судалснаараа шинэлэг талтай.

Багш нарын хамтын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга замаар багшийг хөгжүүлэх боломжийг судалснаараа шинэлэг юм.

# НЭГ : ОНОЛЫН ХЭСЭГ

**Багшийн хөгжил**

Боловсрол олгодог бүх шатны байгууллага нь боловсролын салбарын өөрчилөлт, шинэчлэлийн шинэ зорилго, зорилтыг өндөр мэдлэг чадвартай багш нарын хүчээр хэрэгжүүлсний үр дүнд иргэдэд чанартай, үр өгөөжтэй боловсролын үйлчилгжээ үзүүлж чадна. Манай ард түмний өв уламжилалд эрдэм мэдлэгтэй бүхнийг багш хэмээн нэрлэж ирсэн байдаг.

Өнөө үед багш гэдэг бол өсвөр залуу үеийхний амьдраллд нь хэрэгтэй мэдлэг чадвар олгох тэднийг бие хүн болгон хүмүүжүүлэх төлөвшүүлэх амьдрах ухаан олгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй хийх мэргэжлийн ур чадвартай хүн юм. Боловсролын шатны бүх байгууллагын үр нөлөө , ашигтай үйл ажиллагаа явуулах гол нөөц эь өндөр мэдлэгтэй, чадварлаг багш бөгөөд гадаад дотоод орны байнгын өөрчлөлт нь багш нараас цаг үргэлж өөрчлөгдөн хөгжиж байхыг шаардаж байна. Орчин үед нэг талаас нийгмийн амьдралд нөгөөтэйгүүр суралцагчийн эрэлт хэрэгцээ, сонирхол эрчимтэй өөрчилөгдөх боллоо. Эдгээрийг багш байнга мэдэрч сурган хүмүүжүүлэх ажлаа зохицуулан өөрчилж боловсронгуй болгох чадвартай байх нь чухал. Өөрчлөлт гэдэг нь нэг ёсондоо хөгжил юм.

Тэгвэл багшийн хөгжил гэж юу вэ? Багш юугаа өөрчлөх шаардлагатай вэ? Багш яагаад хөгжиж байх хэрэгтэй вэ? Гэсэн олон асуултууд урган гарч ирэх болно. Тэгвэл

1. Чанартай сургалт, үр өгөөжтэй мэдлэг олгохын тулд
2. Хүүхэд багачууд, суралцагчдыг хөгжүүлэх, чадваржуулахын тулд багш хөгжих шаардлага гарч байна.

Багшийн хөгжил гэдэг нь тухайн нийгэм, соёл бусад багш нар, суралцагч, эцэг эх,

олон нийт, мэргэжлийн орчинд орж, өдөр тутам харилцаж, хамтран ажиллаж байгаа хувь хүний өөрөө хөгжих үйл явц юм. Мөн өөрөө багш мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг, арга барил, ур чадвар, үзэл бодол, харилцаа хандлага, сэтгэлгээ зэргээ бие даан ухамсартай өөрчилөн сайжруулах чиглэлтэй үйлдлүүдийг хийх явдал юм. Багшийн хөгжлийн үйл явц нь тэдний өөрсдийнх нь идэвхи оролцоо, санаачлага, хүсэл тэмүүлэл дээр тулгуурладаг.

Багшийн хөгжил бол тасралтгүй, өсөн дээшилж шинэчлэгдэн явагдаж байдаг. Багшийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйл нь :

- ✓ Сургах таатай боломж
- ✓ Сурах хүсэл тэмүүлэл гэсэн 2 үндсэн хүчин зүйлтэй.

Сурах таатай боломж гэдэгт багш хөгжих бололцоо нөөцийн чадахи болно. Тасралтгүй хөгжлийг дэмжих, шахаж шаардах боловсролын тогтолцоо нь бүтцийн болон хэв хэмжээний хувьд хэрхэн уян хатан нээлттэй бүрэлдэн тогтсон байдал хоёрыг багтаан ойлгож болно.

Сурах хүсэл тэмүүлэл гэдэгт багш байнга цаг үеэ мэдэрч, үргэлж бусдын сонирхолыг нь татаж байдаг. Хөгжихийн хэрээр сайхан амьдарч ажиллах нөхцөл бшрэлддэг байх, сэтгэл санааны болон материаллаг урамшуулал, шагнал дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх нээлттэй ил тод тогтолцоо түүний үйл ажиллагааг авч үзэж болох юм.



Схем -1




**Техникийн** : үзэл баримтлалд багшийг хичээлийн хөтөлбөр мэргэжлийн талаас бүрэн ухаарсан эв дүйтэй үйл ажиллагаанд сругаж хөгжүүлэх

**Шинэжээчийн** : үзэл баримтлалд багш өөрийгөө хөгжүүлж сурган хүмүүжүүлэх мэдлэгээ хэрэглэн амьдралд тохиолдох түгээмэдл асуудлыг өөрийн аргаар шийдвэрлэх

**Экологийн** : үзэл баримтлалд багшийнамьдралын түүхийг судалсан олон жилийн үр дүн, багш бүр ажил амьдралын явцад өсөн бойжих зэрэг олголт юм. Багшийн хөгжих үйл явцын үр дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, шинэ хандлага, шинэ итгэл знэмшил зэрэг соёлын үнэт зүйл бүтээн өөрчлөлт шинэчилэлт бий болно.

**Багш хөгжих арга зам**

Улс орон зах зээлийн харилцаанд шилжсэн өнөө үед багш мэдлэг чадвараа үргэлж дээшлүүлж, сурган хүмүүжүүлэх рага барил, ур чадвараа боловсронгуй болгох, сурган хүмүүжүүлэх сэтгэлгээгээ шинэчлэх шаардлагатай болсон. Үүнтэй холбогдуулан дараах хэрэгцээ гарч ирнэ.

- ✓ Нийгмийн хэрэгцээ шинэжлэх ухаан техникийн хөгжилд дэлхий дахины даяарчлал, улс нийгэмд өндөр мэдлэг чадвартай боловсон хүчин бэлтгэх шаардлагатай энэ үед суралцагчидад чадварлаг багш хэрэгтэй байгаа нь нийгмийн зүй ёсны шаардлага юм.
- ✓ Суралцагчидын хэрэгцээ: мэдээлэл техонлогийн эрин үе учир хүүхүүд мэдээллийг абгш нараас түрүүлэн авч байгаа учир багш нараас үргэлж шинэ мэдээллийг шаардаж байдаг. Хүүхэд өөрийнхөө авъяасыг

хөгжүүлэх амьдралд хэрэгтэй мэдлэг чадвартай болохын тулд өндөр мэдлэг чадвартай багшийг шаардаж байдаг.

- ✓ Зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд ажлын байраа хадгалах шаардлагаас гарах хэрэгцээ
- ✓ Нэр хүндээ өсгөх, албан тушаал ахих, ашиг орлого дээшлүүлэх хэрэгцээ: эдгээр хэрэгцээнүүдийг хангахын тулд багшаас өндөр мэдлэг боловсорл, ур чадвар, харилцааны өндөр соёл , хүүхэдтэй ажиллах эв дүй зэргийг шаардаж байдаг. Хэрвээ багш хүн өөрийгөө боловсруулан хөгжүүлж чадвал тэр хэмжээгээрээ улс орны боловсролын хөгжил дэвшлийг хурдасгахад чухал хувь нэмэр оруулж чадна.

Багшийг хөгжүүлэх хөгжих хэрэгцээг хангахын тулд дараах шаардлагыг хангасан байна.

- ✓ Багшийг хөгжүүлэх арга хэмжээ нь багш нарын болон сургуулийн эрэлт хэрэгцээ байх
- ✓ Тодорхой төлөвлөгөөтэй байх
- ✓ Багшийг хөгжүүлэх явдлын үр ашиг, нөлөөтэй болохын тулд бүх нөөц быололцоогоо ашиглах
- ✓ Багш бүрийг хамарсан, зардал үр дүнтэй байх
- ✓ Багшийн хөгжил нь урамшуулан дэмжхийг шаардаж байх.

Аливаа сургалт нь багшийг сургах, сургуулийг өөрчлөн шинэчлэх хэрэгсэл юм. Багш сургалтанд хамрагдсанаар шинэ мэдлэг олж авах, түүнийгээ ажилдаа хэрэглэх, ур чадвараа дээшлүүлэх боломж болно. Гэвч багшийг хөгжүүлэх рага замыг дан ганц сургалт гэж үзэж болохгүй. Тэрчлэн судалгаа хийх, илтгэл бичих , ном бүтээл туурвих, хурал семинар дадлага зохион байгуулах , туршилт хийх зэрэг нь хөгжих арга зам юм.

**Багш хөгжих шаардлагатай юу**

Улс орны хөгжил боловсролын хөгжлөөс, боловсролын хөгжил сургуулийн хөгжлөөс, сургуулийн хөгжил багшийн хөгжилөөс шалтгаалдаг учир юуны өмнө багш нарын ажиллах, сурах хүсэл тэмүүлэлийг дэмжих, урамшуулах тодорхой зорилго, зорилтоттой байж хамтран ажиллах чадвартай хамт олныг бүрдүүлэх бодлого барих нь чухал юм. Багш нар өөрийн бүтээлч хүчээ чөлөөтэй дайчлан

хөгжүүлэх бүрэн боломжтой ба тийм орчинг бий болгосоноор сургууль багш хөгжих юм.

Багшийн хөгжил нь хүүхдийн хөгжилэй холбоотой ба хөгжиж буй багш л хүүхдийг хөгжүүлж чадна. Орчин үед багш бол " Мөнхиий сурагч" тэрээр өөрөө болон бусдаас байнгын суралцаж байх шаардлагатай байна. Багш бусад багш нараас, сурагчидаас, эцэг эхээс, ном сонин, сэтгүүл, радио, телевиз зэргээс суралцаж байх хэрэгтэй. Ер нь өнөө үед багшид өөрийгөө хөгжүүлэх нөөц боломж байгаа ба энэ нь гагцхүү багшийн идэвхи зүтгэл, бүтээлч байдал, хүүхэдтэй харилцах харьцааг хэрхэн зохицуулахад чиглэл болох үүрэг бүхий норм хэм хэмжээний систем юм. Энэ нь ёс зүйн тухай мэдлэг, итгэл үнэмшил, эв дүй, ур чадвар хэвшил зэргээс бүрдэнэ.

## ХОЁР : СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## ХАМТЫН АЖИЛЛАГААНД СУУРИЛСАН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ БА ОРЧИН ҮЕИЙН БАГШИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хамтын ажиллагаа гэдэг бол Арга билгийн харилцаа билээ. Өөрөөр хэлбэл аргын тал буюу Оролцоо, Билгийн тал буюу Харилцаа энэ хоёр талын нэгдэхүй түүний үр дүн юм. Оролцооны талаа дагаж харилцаа нь хөдлөнг болно. Харилцаагаа түшиж Оролцоо нь тогтворжиж, энэ бүхний үр дүнд зүй зохистой хамтын ажиллагаа өрнөнө. Энэ бол Оролцоогүйгээр харилцаа хамтын ажиллагаа бий болдоггүйн учрыг агуулсан гүн ухааны зарчим мөн.

### Хамтын ажиллагаанд суурилсан хөгжлийн тухай ойлголт

**Хамтын ажиллагаа гэж юу вэ? Манай сургууль хамтын ажиллагааны хувьд аль байгууллагатай түлхүү хамтран ажилладаг вэ?**

А. Багш багштайгаа хамтран ажилладаг хамтын ажиллагааны түвшин 45,88%

Б. Нутгийн удирдлагын байгууллагуудын хувьд харилцаа, хамтын ажиллагааны түвшин 32,05 хувьтай байгаа бол

В. Бүс нутгын хэмжээнд хамтран ажиллах түвшин 35,26 хувь

Г. Яамдын түвшинд 45,87 хувь

Д. Агентлагуудын харилцаа, хамтын ажиллагаа 47,09 хувьтай гарсан байна.

Дээрх үнэлгээнүүдийн дундаж нь 41,23 хувьтай байна. Өөрөөр хэлбэл 58,77 хувиар харилцаа, хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлага байна.

- ✓ Нэгэн харилцаанд хүрэхэд чиглэсэн хүмүүсийн хамтын , харилцан сурах, сургах үйл явцын цогц буюу тогтолцоо, түүний үр дүн буюу оролцогч тус бүрд бий болсон хөгжлийн ахиц
- ✓ Нэгэн зорилгод хүрэхэд чиглэсэн хүмүүсийн хамтын ажилбарууд үр дүн, хувь хүн дэх өгөөж
- ✓ Хэсэг бүлэг хүмүүс тодорхой даалгаварыг хамтран харилцан үйлдэхүй, түүний үр дүн

**Хамтын ажиллагааны үр дүнд хувь хүнд оногдох боломж**

- ✓ Хөгжих хэрэгцээ, сэдлийн үр дүн нэмэгдэх
- ✓ Оюунаа дайчлан өөрөө мэдлэг бүтээх замаар ухаанаа тэлэх
- ✓ Оюун ухаанаа хөгжүүлэх явцдаа нийгэмших, иргэнших буюу хүнших
- ✓ Өөрийгөө болон бусдын хөгжил дэх хувийн хариуцлагыг ойлгон ухамсарлах
- ✓ Хэлний болон харилцааны чадамж дээшлэх
- ✓ Бусадтай хамтран ажиллах арга барилд суралцах
- ✓ Өөрийн сайн талыг мэддэг болдог буюу сэтгэцийн эрүүл сайжрах

Давуу тал

- ✓ Хувь хүмүүсийн хооронд эерэг буюу нааштай харилцан хамаарал ба нөлөөлөл бий болдог
- ✓ Хувийн болон хамтын хариуцлага хүлээдэг.
- ✓ Суралцагчдад бие биетэйгээ нягт харилцан хамтран ажиллахад түлхэц өгдөг
- ✓ Суралцагсад бусдыг ойлгох, тэдэнтэй хамтран ажиллах арга технологи эзэмшидэг.

**Хамтын ажиллагаанд суурилсан хөгждөг сургуулийн шинж**

- ✓ Нээлттэй сургууль болсон байх
- ✓ Сургууль нь хамтын ажиллагаанд суурилсан хөгжлийг дэмжих бүтэц зохион байгуулалттай байх.
- ✓ Багш хамтдаа хөгжих иж бүрэн орчин " материаллаг, эрх зүйн, үйлийн, сэтгэл зүйн" бүрдсэн байх.

**Хамтран ажилласнаар багийн гишүүд нь**

- ✓ Дэмжлэг туслалцаа, нөлөө үзүүлдэг ба хөгжил үзүүлдэг
- ✓ Мэдээлэл, эд зүйлсээ харилцан солилцдог
- ✓ Нөхдийн хэлсэн баримтыг аль болох өөртөө ашигтай болгох талаар чармайдаг
- ✓ Бие биенийхээ зан төрх мэдлэг чадварыг илүү сайн ойлгодог, нийгэмшдэг иргэншдэг.
- ✓ Өөр өөрийн үзэл бодлоо уралдуулж сайжруулдаг
- ✓ Бие биенийгээ аль болох сайн сурахад дэмжлэг үзүүлдэг.

- ✓ Сурах сэдэл тэмүүлэл сайжирдаг буюу эрчимждэг
- ✓ Харилцан илтгэлцэл бий болдог
- ✓ Сэтгэлийн төлөв байдал тогтворждог гэж үзжээ.

Эндээс үзэхэд өнөөдөр багш нар ганцаарчилсан буюу өрсөлдөөний хэлбэрээр сурч ажиллаж байгаа учраас хамтын ажиллагаанд суурилсан бүтээлч хөгжил явагдахгүй байгаа юм. Сүүлийн үед боловсролын салбарт яригдаж байгаа чухал асуудлын нэг нь хөрвөх чадвартай багш юм. Бие даасан бусад шинжлэх ухаантай холбогддоггүй шинжлэх ухаан гэж үгүй. Тэгвэл энэ хичээлүүдийг нэг л багш заах боломжтой гэж үзээд багшид ийм шаардлага тавьж эхлээд байна. Мөн сургалтын явцад багш, суралцагчийн харилцаа, харилцан нөлөөлөл, хамтын үйл ажиллагаа өргөн хүрээтэйн зэрэгцээ бие хүний хувьд бие биенээ хөгжүүлдэг. Багш мэргэжил нь олон талтай өвөрмөц онцлогтой.

**Орчин үеийн багшид тавигдах шаардлага нь**

- ✓ Харилцааны өндөр соёлтой
- ✓ Зохицуулан, зохион байгуулалт чадвартай менежер
- ✓ Мэргэжлийн боловсрол өндөртэй
- ✓ Сурган хүмүүжүүлэх соёлтой
- ✓ Оношлон судлах болон эрдэм шинжилгээний ажлын арга барилтай байх гэж үзжээ.

**БАГШИЙН ХӨГЖИЛД ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НӨЛӨӨЛӨХ НЬ**

- ✓ Нийгмийн хөгжил
- ✓ Боловсролын хөгжил
- ✓ Сургуулийн хөгжил
- ✓ Багшийн хөгжил
- ✓ Хамтын үйл ажиллагаа
- ✓ Суралцагчийн хөгжил

***Жишээ:***

***Бусад байгууллагаатай хамтран ажиллаж бие биеэ нөхөж ажилласанаар ийм шат дараатай хөгжил ирнэ. Гэж ойлгож байна. Багш та юу гэж бодож байна вэ?***

Ажил мэргэжилд гарч байгаа өөрчлөлт нь тийм ч эрсдэлтэй зүйл биш. Эрсдлийн менежментийн хамгийн бүтээлч стратеги бол үнэн хэрэгтээ хамт олны дундах нээлттэй, бүтээлч, нөхөрсөг хамтын ажиллагаа юм. Хамтран ажиллаж буй багш нартай санал, бодол туршлагаа солилцох санаа зовоосон буюу эргэлзээтэй асуудлаа илэн далангүй ярилцаж эхэлж буй багш нар бүгд санал нэгтэйгээр нээлттэй бүтээлч хамтын ажиллагаанаас их зүйлийг мэдэж авдаг гэж ярьцгаадаг. Багш нарын мэдлэг чадвар өөр өөр байдаг. Тэд харилцан адилгүй мэдлэг чадвараа харилцан солилцох, хамтран ажиллах уур амьсгал бүрэлдэж чадваас мэдлэг чадварын хэмжээ, сан аривжих болно.

- ✓ Багш нарын хамтын ажиллагаа нь багшийг өөрийн сургахуйн практик үйлийг системтэйгээр тасралтгүй дахин дахин эргэцүүлдэг болгодгоороо сургахуйн чанарыг сайжруулах дэмжин туслахад магадгүй хамгийн чухал байж болох юм.
- ✓ Ахмад залуу багш нарын хамтын үйл ажиллагаа идэвхжиж, ахмад үеийхний хуримтлуулсан баялаг туршлагын үнэ цэнийг мэдрэх, залуу үеийхний ололттой давуу талыг дэмжих хандлага нэмэгдэж байгаа нь өнөөгийн боловсролын хөгжилд оруулж буй нэгээхэн хувь нэмэр болж байна.

**Хамтын ажиллагааны үр дүн**

1. Байгууллага хоорондын харилцаа сайжирна.
2. Залуу ахмад багш нарын хамтын ажиллагаа ихээхэн нээлттэй болох
3. Ахмад багш нар залуу багш нарын хичээлд ажиглалт хийхдээ, хичээлийн төлөвлөлтийн шатнаас эхлэн хамтран ажилладаг тул залуу багшийн алдаанд ач холбогдол өгөхөөсөө илүүтэй алдаа гаргасан шалтгааныг хоёр талаас нь тодорхойлж дахин алдаа гаргахгүй байх аргыг залуу багшид эзэмшүүлэх.
4. Залуу багш нарт сурган хүмүүжүүлэх ажлын хат суулгахад ахмад багш нар нөлөөлөх. Иймд бид бүхэн ахмадуудаасаа байнга суралцаж байх нь дээрх үр дүнгээс харагдаж байна.

## БАГШ АЖЛЫН БАЙРАНД ХӨГЖИХӨД ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА НӨЛӨӨЛӨХ НЬ

Хүнд арга барилаа үзүүлэх болон хүний арга барилыг үзэж таних хоёр талдаа хөгжин дэмжих боломжийг олгодог сайн талтай байдаг бөгөөд иймээс ч хичээлийн судалгааг тухайн хүн орчин тойрных нь бүгд цугтаа хөгжихөд зохимжтой байдаг алхам гэж үздэг. Хичээлийн судалгааг хийснээр багш нар ажлын байрандаа олон талаар хамтран хөгжих үндэс болох ба суралцагсдын мэдлэг чадварыг хэрхэн хөгжүүлэх талаар тодорхой хөгжүүлэх зорилго бүхий материалтай болж асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдэх боломж бүрдэнэ.

Хичээлийн судалгаа нь сургуулийн сургалтын үйл ажиллагаанд суурилсан тул бүхий л сургуулийн ямар ч хичээлд хийгдэх боломжтой төдийгүй өөр сургуулийн багш нар хамтран нэг нэгийнхээ судалгааны материал, хичээлтэй танилцан туршлага солилцох, хамтран ажиллах боломж олгодог.

## ӨРНӨ БА ДОРНЫ ОРНУУДЫН МОНГОЛД ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ ТУРШЛАГУУД

Багшийн боловсролыг хөгжлийг дэвшүүлэх асуудлыг зарим орнуудын жишээнээс авч үзье.

- ✓ АНУ-д багш нарын мэргэжил дээшлүүлэх зорилготой багш нарын холбоо үндэсний боловсролын нийгэмлэг гэсэн 2 байгууллага ажилладаг. Энэ нийгэмлэгт багш нар сонголтоороо элсэж мэргэжлээ дээшлүүлэх хамтран хөгжих боловсрох талаараа бодлогын дэмжлэг авч байдаг. Сонирхол нэгтэй багш нарыг уулзах боломжоор хангах, захиалгын дагуу хурал зөвөлгөөн зохион байгуулах, сэтгүүл гаргах, гарын авлагаар хангах, шинэ мэдээллийг түгээх зуучлах, зөвөлгөө өгөх, зуны сургалт семинар илтгэлийн чуулган зохиох зэргээр багшийн хөгжлийг дэмжих олон хэлбэрийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээрт багшийн өөрийн оролцоо хамтач байдал чухал нөлөө үзүүлдэг. Бага сургуулийн багш нь байнга солигддог. Өөрөөр хэлбэл жил бүр 2-р ангид заана гэсэн үг. Энэ нь багш мэргэшинэ гэсэн үг юм.

- ✓ Герман улсад багшаа хөгжүүлэхэд онцгой анхаарч захиалгат сургалт семинарыг туршлага мэдлэгтэй эксперт дидактин багшаар удирдуулан байнга зохион байгуулдаг. Багшийн цалин хамгийн өндөр байдаг.
- ✓ Дани улсад багшийн хөрвөх чадварыг гол шалгуур болгодог. Иймд хэд хэдэн хичээлийг заах чадвартай болсон байна. Шавь төвтэй сургалтыг онцолдог.
- ✓ Финланд улсад багш нар бүгд магистр хамгаалах ёстой. Үүнийгээ хуульчилсан байдаг учраас багшийн нэр хүнд асар өндөр бөгөөд дээр үеэс " Ард түмний лаа" хэмээн хүндэтгэн үздэг байжээ. Өдрийн хоолыг улсаас даадаг мөн багш болох хүүхдийг зориуд сонгож авдаг. Тухайн сэдвийг заавал эзэмшиж дараагийн алхамд ордог нь финланд улсын боловсролын гайхамшиг юм.
- ✓ Солонгос улсад хичээлийн судалгааг гол болгон оруулж багш хамтарч ажлын байрандаа мэдлэг арга зүйгээ дээшлүүлэхэд бие биенээсээ суралцаж бие биедээ зөвлөгөө өгч хөгжүүлэхэд ихээхэн анхаардаг байна. Мөн төгсөгчдийн шилдэг 5% дотроос багш болох хүүхдийг сонгодог.

## БАГШ НАРЫН ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМААР БАГШ НАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖУУД

Багш нарын мэргэжлийг БСШУЯ-ны сайдын 2008 оны 72-р тушаалаар батлагдсан " сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх журамд" анхны жил, 5 дахь жил, 10 жилдээ ажиллаж буй багш нар мэргэжил дээшлүүлэх гэж заасан болович хэрэгждэггүй.

- ✓ 1990 оноос өмнө багшийн мэргэжлийг 5 жил тутамд дээшлүүлдэг байсан уламжлал орхигдсон ***/ энэ одоо байдаг болович үүнийг хэрэгжүүлэх/***
- ✓ Багш нар ажлын байрандаа хөгжихөд багш хөгжлийн танхим зайлшгүй хэрэгтэй байдаг.БСШУЯ -ны сайдын 114-р тушаал хэрэгжихгүй удаж байна.

  ***/энэ одоогоор байгуулагдсан ч яг зорилгоо биелүүлж үр ашигаа өгч байгаа юу/***

- ✓ Багш бие даан ажлын байран дээр хөгжих олон арга байгаа бөгөөд багш нарын зөвөлгөөн, ЗАН-р дамжуулан хамтын удирдлагын үндсэн дээр зөв зохион байгуулж чадваас багшийг бүр тодорхой зорилготойгоор сурган хүмүүжүүлэх ур чадвараа сайжруулж чадна.
- ✓ Аймаг орон нутгын боловсрол соёлын газартай хамтран ажиллаж ерөнхий боловсролын ЗАН-д хамрагдаж түүнээс зохион байгуулж буй сургалт, арга хэмжээнүүдэд оролцох.
- ✓ Анги даасан багш мэргэжлийн багш хамтран аль байгууллагатай ямар чиглэлээр хамтарч ажиллаж болох талаар төлөвлөгөө гаргаж, баталгаажуулан түүнийг хэрэгжүүлэх боломжийг эрэл хийх.
- ✓ Багш бүр нийгмийн түншлэлийн албатайгаа хамтран ажиллах
- ✓ Мэргэжил дээшлүүлэх талаар сургуулийн удирдлагын зүгээс багш нараас санал асуулга авч тодорхой цаг дараалсан үйл ажиллагааг зохиох зэрэг шаардлагууд урган гарч байна.
- ✓ Бүс улс, олон улсын тэмцээн уралдаанд оролцогч багш суралцагчиддаа ажил олгогч, инженер техникийн ажилтан бусад холбогдол бүхий байгууллагаас зөвөлгөө тусламж авч хамтран ажиллаж байх.

**Хэрэглээний түвшин үр дүн**

Хичээл ордог ангиудаасаа болон бусад сургуулийн нийт 100 суралцагчаас сайн багшийн шинж, амжилт муутай багшийн шинжүүдийн талаар цахим судалгаа авч анализ хийж үзлээ. Ингэхэд ерөнхийдөө

**Сайн багшийн талаар:**

- ✓ Хичээлийг жишээгээр ойлгомжтой тайлбарладаг байх.
- ✓ Суралцагчийг хичээлд дуртай болгох
- ✓ Зарим үед өөрийгөө суралцагчийн оронд тавьдаг байх
- ✓ Суралцагчтайгаа найзархаг байх
- ✓ Суралцагчидтайгаа хамт нийгмийн үйл ажиллагаанд оролцдог байх
- ✓ Ялангуяа найз нөхдийн хажууд ичээх элдвээр доромжилж болохгүй
- ✓ Дүнгээр айлгадаггүй байх
- ✓ Суралцагчдын төлөө санаа тавьдаг байх
- ✓ Юмыг сайнаар хардаг хөгжилтэй элдэг байх гэжээ.

Эндээс үзэхэд багш ямагт суралцагчиддаа үлгэрлэдэг болох нь харагдаж байна.

**Харин амжилт муутай багшийн шинжийг**

- ✓ Сургалтын арга барилаа сайн ашиглаж чаддаггүй
- ✓ Заах хичээлээ сайн эзэмшээгүй
- ✓ Өөрийн гэсэн тодорхой байр суурьгүй
- ✓ Суралцагчийн авъяас чадварыг дэмжих таних даа муу
- ✓ Суралцагчдынхаа талаар мэддэгггүй гэжээ.

Эндээс үзэхэд багш бүр энэ шинж чанараасаа салж чадвал багш хөгжиж байгаагийн илрэл мөн.

## БАГШ АЖЛЫН БАЙРАН ДЭЭР ХӨГЖИХӨД БАГШ НАРЫН ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Судалгаанд Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн багш, Говьсүмбэр аймаг дахь Ерөнхий боловсролын сургуулиудаас түүвэрлэн сонгосон нийт 35 багшийг хамруулсан.

1. Та яагаад багш мэргэжлийг сонгосон бэ?

   А. Сонирхолтой учир

   Б. Аав ээжийн зөвөлгөөг дагасан

   В. Сургуульгүй үлдсэн учир

   Г. Өөрийн хүсэлтээрээ
2. Багш өөрийгөө хөгжүүлэхэд таны бодлоор юу хийх хэрэгтэй вэ?

   А. Хамтран ажиллах нөхдөөсөө суралцах

   Б. Аливаа сургалтанд хамрагдах

   В. Биеэ дайчлах

   Г. Ганцаарчилан суралцах
3. Багшийн нарын хамтын үйл ажиллагаанд удирдлагын оролцоо хэр нөлөөтэй вэ?

   А. Нөлөөлнө

   Б. Дунд зэрэг

   В. Маш их

Г. мэдэхгүй

4. Манай болон танай сургуулийн багш нарын хамтын үйл ажиллагаа ямар түвшинд байна гэж үзэж байна вэ?

   А. Маш сайн

   Б. Сайн

   В. Дунд зэрэг

   Г. Хангалтгүй

5. Таны бодлоор багшийн нарын хамтын үйл ажиллагаа ямар нөхцөлд мэргэжлээрээ илүү хөгжих боломжтой вэ?

   А. Сургалтанд хамрагдсанаар / хамтын үйл ажиллагаа/

   Б. Ажлын байрандаа хамтран суралцаж туршлага хуваалцсанаар

   В. Техник технологи сайн эзэмшсэнээр

   Г. Өөрийн мэргэжлээрээ гадаад, дотоодын сургуулиудын багш нартай хамтран ажиллаж туршлага судалсанаар

6. Багш нарын хамтын үйл ажиллагааны үр нөлөө юу байх вэ?

   А. Багш нарын хичээлтэй танилцан туршлагаа солилцох боломж олгодог
   Б. Судалгааны материалтай болж түүн дээр тулгуурлан сургалтанд ашиглах боломжтой болдог
   В. Багш нар хамтран ажиллах боломж олгодог
   Г. Ахмад, залуу үеийн багш нарын хамтын ажиллагаа идэвхжих боломжтой болдог

**Асуулт 1: Та яагаад багш мэргэжлийг сонгосон бэ?**



*График 1*

Судалгаанд оролцогчдын 14 буюу 41% сонирхолтой учир, 10 буюу 29% өөрийн хүсэлтээр, 7 буюу 21% сургуульгүй үлдсэн учир, 3 буюу 9% нь аав ээжийн зөвлөгөөг дагасан гэж хариулсан нь багш нар маань өөрийн сонирхолоор мэргэжилээ сонгосон байгаа нь давуу тал юм.

**Асуулт 2: Багш нар өөрийгөө хөгжүүлэхэд таны бодлоор юу хийх хэрэгтэй вэ?**




*График 2*

Судалгаанд оролцогчдын 15 буюу 42% нь хамтран ажиллаж нөхдөөсөө суралцах , 10 буюу 29% нь аливаа сургалтанд хамрагдах, 8 буюу 23% нь биеэ дайчлах, 2 хүн буюу 6% нь ганцаарчилан суралцах гэж хариулсан нь багш өөрийгөө хөгжүүлэхэд хамтран ажиллаж нөхдөөсөө суралцах аргыг ихэвчлэн хэрэглэдэг байна.

**Асуулт 3: Багшийн нарын хамтын үйл ажиллагаанд удирдлагын оролцоо хэр нөлөөтэй вэ?**




*График 3*

Судалгаанд оролцогчдын 20 буюу 57% нь нөлөөлнө, 10 буюу 28% нь дунд зэрэг, 3 буюу 9% нь нөлөөлөхгүй, 2 хүн буюу 6% нь мэдэхгүй гэж хариулсан нь багшийн хамтын үйл ажиллагаанд удирдлагын оролцоо маш чухал гэдэг нь судалгаанаас харагдаж байна.

**Асуулт 4: Манай болон танай сургуулийн багш нарын хамтын үйл ажиллагаа ямар түвшинд байна гэж та үзэж байна вэ?**



*График 4*

Судалгаанд оролцогчдын 14 буюу 40% нь дунд зэрэг, 11 буюу 31% сайн, 7 буюу 20% нь маш сайн, 3 буюу 9% нь хангалтгүй гэж хариулсан нь сургуулийн багш нарын хамтын үйл ажиллагаа дунд зэрэг гэж үзсэн байна. Маш сайн болгохын тулд цаашид илүү олон аргыг ашиглах шаардлагатай байгаа нь графикаас харж болно.

**Асуулт 5:** Таны бодлоор багшийн нарын хамтын үйл ажиллагаа ямар нөхцөлд мэргэжилээрээ хөгжих боломжтой вэ?




*График 5*

Судалгаанд оролцогчдын 24 буюу 69% / өөрийн мэргэжлээрээ гадаад, дотоодын сургуулиудын багш нартай хамтран ажиллаж туршлага судалсанаар, 6 буюу 17% ажлын байранд хамтран суралцаж, туршлага хуваалцсанаар, 4 буюу 11% нь сургалтанд хамрагдсанаар, 1 буюу 3% нь техник технологи сайн эзэмшсэнээр гэж хариулсан нь багш нарын хамтын үйл ажиллагаа нь өөрийн мэргэжлээрээ гадаад, дотоодын сургуулиудын багш нартай хамтран ажиллаж туршлага судлах нь үр дүнтэй гэдэг нь харагдаж байна.

**Асуулт 6:** Багшийн нарын хамтын үйл ажиллагааны үр нөлөө юу вэ?




*График 6*

Судалгаанд оролцогчдын 22 буюу 62% ахмад, залуу үеийн багш нарын хамтын ажиллагаа идэвхжих боломжтой, 8 буюу 21% багш нарын хичээлтэй танилцан туршлагаа солилцох боломж олгодог, 3 буюу 10% нь судалгааны материалтай болж түүн дээр тулгуурлан сургалтанд ашиглах боломжтой болдог, 2 буюу 7% нь багш нар хамтран ажиллах боломж олгодог гэж хариулсан нь багшын хамтын үйл ажиллагааны үр нөлөө нь ахмад, залуу үеийн багш нар хамтран ажиллаж бие, биенээсээ суралцах нь үр дүнтэй гэдэг нь судалгаанаас харагдаж байна.

## ДҮГНЭЛТ

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд

- ✓ Бидний судлагааны үр дүн багш нар ажлын байрандаа хөгжихөд хамтран ажиллах хамтран бие биенээсээ суралцах үйл ажиллагаа хамгаас чухал гэдгийг харуулав
- ✓ Сургуулийн удирдлагууд багш нараас нээлттэй асуулга авч багш нарын хамтын үйл ажиллагааг дэмжсэн тодорхой асуудлуудыг зохион байгуулах
- ✓ Сургуулийн хэмжээнд багш нар хамтран хөгжих хөтөлбөр гаргах ингэснээр сургалтын чанар сайжирч өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
- ✓ Багшийн ёс зүйг хамгаалсан эрх зүйн орчин бүрдүүлэх, ажил дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай орчинг "Багш хөгжлийн танхим" бүрдүүлэх тасралтгүй ашиглах
- ✓ Аймаг бүсийн БСГ-ын ажлын нэгж дээр ирж онол арга зүйн зөвлөгөө өгч үзүүлэх хичээл заах хичээлийн болон бусад асуудлаар нээлттэй ярилцлага зохион байгуулах.
- ✓ Ахмад багш нарыг урьж сонирхолтой зөвлөгөө санал бодлыг нь байнга сонсох
- ✓ Мэргэжлийн зэрэгтэй багш нарын зөвлөгөө зохион байгуулж туршлага хуваалцах
- ✓ Ахмад дунд залуу үеийн бүлэг байгуулж олон талт асуудлаар хамтран ажиллах бие биеэсээ суралцах
- ✓ Хичээлийн судалгаа явуулснаар багш ажлын байран дээрээ олон талаасаа хамтарч ажиллах хөгжих үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдэх нь харагдаж байна.

## ИЛТГЭЛИЙН ТӨГСГӨЛД:

- ➢ Чадварлаг нь боломжийг бүтээдэг
- ➢ Оюунлаг нь боломжийг ашигладаг
- ➢ Залхуу нь боломжийг хүлээдэг
- ➢ Сул дорой нь боломжийг алддаг

## НОМ ЗҮЙ


1. Ш. Ичинхорлоо /2008/ "Багшийн ном" УБ
2. Х. Ганбат /2002/ "Ажлын байранд хөгжүүлэх онол арга зүйн асуудал"
3. Ц. Оюун /2005/ "Багшийн хөгжил" УБ
4. Б. Жадамбаа, У. Чимэдлхам /2001/ "Судалгааны арга зүй" УБ
5. Ч. Байгалмаа /2003/ "Багшийн мэргэжлийн хөгжлийн туршилт судалгаа"
6. Боловсрол судлал сэтгүүлийн цувралууд /2011 - 2013/
7. www.google.com
8. www.google.mn


## ӨӨРИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Овог нэр:** Лувсандорж овогтой Энхмөнх

**Сургууль:** УУЖС Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

**Мэргэжил:** Биеийн тамирын багш

**Ажилласан жил:** 23

**Боловсролын зэрэг:** Магистр

**Мэргэжлын зэрэг:** Тэргүүлэх

**Спортын зэрэг:** Волейболын спортын мастер